

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 5 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

1.1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2019 оны 5 дугаар сарын байдлаар нийт 47 албан бичгийг байгууллагуудаас хүлээн авч, тус байгууллагаас 24 албан бичгийг боловсруулан холбогдох газруудад хүргүүлсэн. Мөн ард иргэдээс 14 өргөдөл гомдлыг хүлээж авсан.

Аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтнууд 5 дугаар сарын 15-наас 16-ны өдрүүдэд Улаанбаатар хотын Удирдлагын академийн Мэргэшил дээшлүүлэх институтэд зохиогдсон “ИТХ-ын төлөөлөгч, ажлын албаны чадавхыг бэхжүүлэх нь” сэдэвт сургалтад хамрагдсан.

5 дугаар сард аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан хуралдаагүй болно.

1.2. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

2019 оны 5 дугаар сард аймгийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн 5 удаа хуралдав. Уг хуралдаанаар аймгийн удирдлагууд тус аймагт долоо хоногт болж өнгөрсөн үйл ажиллагаануудын талаар танилцуулж, хэлтэс, агентлагийн удирдлагуудын хэрэгжүүлсэн ажил, санал, хүсэлтийг сонсож, цаг үеийн асуудлаар нийт 24 үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан ажиллав.

Энэ сард байгууллагад Төрийн шагналаар шагнуулахаар тодорхойлсон хүмүүсийн материал ирээгүй болно.

Тус аймгийн Ногооннуур сумын 9-р багийн нутаг Цагааннуур тосгоны 2 иргэн тарваган тахлын шинж тэмдэг бүхий өвчнөөр өвчилсөн хэрэг гарсан. Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан аймгийн Онцгой комисс шуурхай арга хэмжээ авч, урьдчилан сэргийлэх үүднээс 2019 оны 4-р сарын 30-ны өдрийн 20:00 цагаас эхлэн, 2019 оны 5-р сарын 6-ны өдрийн 20:00 цаг хүртэл 6 хоног Цагааннуур тосгон, Өлгий сум, аймгийн Нэгдсэн эмнэлэгт хорио цээрийн дэглэм тогтоож, орж гарах бүх хөдөлгөөнийг болон сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосон.

Хөл хорио тогтоосон хугацаанд ямар нэгэн шинж тэмдэг илрээгүй дахин тохиолдол бүртгэгдээгүй тул 5-р сарын 6-ны өдөр аймгийн Онцгой комиссын хуралдаанаар хэлэлцэж Зоонозын өвчин судлалын үндэсний төв болон ХӨСҮТ-ийн удирдлагын баг, мэргэжилтнүүдийн саналыг үндэслэн хорио цээрийн дэглэмийг цуцлах шийдвэр гаргасан.

Аймгийн Засаг даргын “Эрүүл хүнс” сарын аян зохион байгуулах тухай 2019 оны А/245 тоот захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Мал эмнэлгийн газар, Эрүүл мэндийн газраас хамтарсан ажлын хэсэг гарч тус аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эмнэлэг, сургууль, цэцэрлэг, олон нийтийн зоогийн газар, зах, хүнсний дэлгүүрт хяналт шалгалт хийж ажиллалаа.

Хяналт-шалгалтын явцад тухайн аж ахуйн нэгжийг үнэлгээний хуудсаар дүгнэж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, цаашид дотоод хяналтаа сайжруулан ажиллахыг үүрэг болгож, ард иргэдийг хоол, хүнснээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжөөр хангав.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 4-р сарын 17-ны өдрийн 150-р тогтоолоор төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажилд улсын үзлэг явуулахаар шийдвэрлэсэн юм.

Энэхүү улсын үзлэг зохион байгуулахтай холбогдуулан мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, улсын үзлэгийн бэлтгэл, зохион байгуулалтын талаар нэгдсэн ойлголт, мэдээлэл өгөх зорилгоор Төрийн албаны зөвлөл, Архивын ерөнхий газар хамтран аймгийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын удирдах ажилтнуудад цахим сургалт зохион байгууллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 тоот зарлигаар жил бүрийн 5, 10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн Бямба гарагийг "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр" болгон зарласан юм.

Уг өдрийг тохиолдуулан аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг 90 гаруй байгууллагын ажилтан алба хаагч нар 5 дугаар сарын 18-ны өдөр Өлгий сумын 4-р баг, "Суат" ХХК-ны төв цэвэрлэх байгууламжийн хашаан дотор болон өөрсдийн ажилладаг байгууллагын эзэмшил газарт урьдчилсан байдлаар нийт 1800 гаруй ширхэг мод тарилаа.

Жендерийн тэгш байдлыг хангах тухай" хууль, "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах" аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Жендэрийн салбар хороо хамтран Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан 1 өдрийн сургалт зохион байгууллаа.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2.1. Санхүүгийн хяналт, аудитын албаны чиглэлээр

5 дугаар сард үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу аймгийн Эрүүл мэндийн газар, аймгийн Цахилгаан, шугам, сүлжээний газрын 2018 оны, Монгол Алтай нурууны улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргаа, аймгийн Авто тээврийн төв, Дэлүүн, Толбо сумдын бүх төсвийн байгууллагуудын 2017, 2018 оны, аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2016, 2017, 2018 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт-шалгалт хийсэн ба заримыг дуусаагүй үргэлжлүүлэн хийж байна.

Мөн иргэдийн өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалтуудыг хийж байгаа ба дээрх шалгалтуудыг хийж гүйцэтгэхийн тулд Удирдамж батлуулан ажилласан болно.

Хяналт-шалгалт явуулж тавигдсан актын төлбөрөөс урьд оны үлдэгдлээс эхний 5 сарын байдлаар өссөн дүнгээр 1337.4 мянган төгрөг, энэ онд бичигдсэн актын төлбөрөөс 323.6 мянган төгрөг, бүгд 1661.0 мянган төгрөгийн төлбөрийг барагдуулсан.

Энэ сард 10 төрлийн удирдамж боловсруулж, батлуулан хяналт-шалгалт хийж ажиллаж байна. Мөн 9 албан бичгийг хүлээн авч, хариу хүргүүлсэн.

Тус албанаас энэ сард 3 албан тоот бичиж, холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан. Мөн 4 төрлийн өргөдлийг хүлээн авч, бичгээр хариу хүргүүлсэн ба хяналт-шалгалтын үр дүнгээр 20 төрлийн төлбөрийн акт тавигдаж, 3 төрлийн албан шаардлага хүргүүлсэн.

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

3.1. Хууль хяналтын үйл ажиллагаа

3.1.1. Хууль, эрх зүйн хэлтсийн мэдээлэл

Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс нь аймгийн Засаг даргын 5 дугаар сарын 85 ширхэг А захирамжийг хянав.

Хууль, эрх зүйн хэлтсийн хууль тогтоомжийн лавлах санд хууль, УИХ-ын болон Засгийн газрын тогтоол, эрх зүйн хэм хэмжээний актыг шинээр бүртгээгүй ба иргэдээс амаар болон бичгээр гаргасан хүсэлт, өргөдлийг хүлээж авч, 5 хүнд зөвлөгөө өгч үйлчлэв.

3.1.2. Шүүхийн шинжилгээний албаны мэдээлэл

№	Үзүүлэлт	Тухайн сар	Өссөн дүн
1.	Криминалистикийн шинжилгээний тоо	10	32
2.	Хэргийн газрын үзлэгт оролцсон тоо	18	139
3.	Гутлын мөр	3	28
4.	Тээврийн хэрэгслийн мөр	1	20
5.	Эвдлэгч багажийн мөр	0	2
6.	Биологийн гаралтай ул мөр	3	4
7.	Бусад ул мөр	11	88
8.	Хонгио хошуу	30	69
9.	Гарын дардас	30	77
10.	Гарын мөр	0	15
11.	Шүүх эмнэлгийн хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоо	23	221
12.	Шүүх эмнэлгийн бэлгийн холбогдолтой шинжилгээний тоо	0	3
13.	Цогцост хийсэн шинжилгээний тоо	3	15
14.	Тусгай шинжилгээ болон химийн шинжилгээний тоо	4	48

3.2. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл (Өссөн дүнгээр)

№	Заалт	Биелэлт, хувь, тоо
1	Цагдаагийн газрын нийт хүлээн авсан гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй өргөдөл, гомдол мэдээлэл	1319
2	Бүх гэмт хэрэг	153
3	Гэмт явдлын улмаас гэмтсэн	43
4	Гэмт хэргийн улмаас нас барсан хүн	5
5	Малын хулгайн гэмт хэрэг	4
6	Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг	19
7	Нийт учирсан хохирол /сая.төг/	568,6 буюу 467,4 сая төг
8	Баривчлагдсан хүн	98
9	Зөрчлийн хуулиар хэдэн хүнийг хэдэн сая төгрөгөөр торгож, арга хэмжээг авч ажилласан байдал	5171 хүнийг 210815,0 төгрөгөөр торгож.
10	Камераар илрүүлсэн зөрчил	620
11	Саатуулагдсан хүний тоо	557
12	Нийт зөрчил	5484

3.3. Онцгой байдлын газрын мэдээлэл

Нэг. Удирдлага зохион байгуулалт, дотоод ажлын талаар

Ногооннуур сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт гарсан тарваган тахал өвчинтэй холбоотой, мөн үерийн улирал эхэлж байгаатай холбогдуулан аймгийн Онцгой комиссыг 11 удаа хуралдуулж үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашид хийх ажлын талаар нийт 21 асуудал хэлэлцэж, 44 шийдвэр гаргасан.

Онцгой комиссын хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гамшиг, аюулт үзэгдлийн хор уршгийг арилгах арга хэмжээтэй холбоотой аймгийн Засаг даргын 10 захирамж гарч бүрэн хэрэгжсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 114 дүгээр тогтоолоор тус аймгийн Цэнгэл суманд Гал түймэр унтраах, аврах 71 дүгээр анги, Дэлүүн суманд Эрэн хайх, аврах бүлэг байгуулагдсантай холбогдуулан нээлтийн арга хэмжээг угтаж анги, бүлгийн байрыг засварлах, гадна орчинг тохижуулах ажил хийгдэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 80 хувьтай явагдаж байна.

Ногооннуур сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэр “Талын толгой” гэх газарт хаваржиж байсан иргэн “Т”, “Р” нар тарваган тахал өвчнөөр нас барж, Өлгий сумын, Цагааннуур тосгон, Улаанбайшинтад хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан Улсын онцгой комиссын даргын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 2 дугаар тушаалаар томилогдсон Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газрын дарга, хурандаа Б.Мандахгэрэлээр ахлуулсан 4 хүний бүрэлдэхүүнтэй Шуурхай бүлэг 2019 оны 05 дугаар сарын 01- 09-ний өдрүүдэд тус аймагт ажиллаж аймгийн Онцгой комисс, орон нутгийн гамшгаас хамгаалах алба, тусгай зориулалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан.

Үер усны улирал эхэлсэнтэй холбогдуулан “Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” аймгийн Засаг даргын удирдамжийн дагуу, Онцгой байдлын газрын 3 алба хаагч, багийн Засаг дарга нартай хамтран Алтанцөгц, Баяннуур, Бугат, Сагсай, Улаанхус, Цэнгэл сумдын Ховд голын эрэг дагуу хаваржиж байгаа айл өрхүүдэд хугацаат мэдэгдэх хуудас өгч ажиллаж байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын “Тэмцээн зохион байгуулах тухай” 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/88 дугаар тушаалаар тус аймагт зохион байгуулагдах Гал унтраах техникийн олон төрөлт спортын “Баруун бүсийн аварга” шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдыг хүлээж авах бэлтгэл ажил бүрэн хангагдаж дууссан ба 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 05-ны өдрүүдэд тэмцээн зохион байгуулагдана.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам батлах тухай” 67 дугаар тогтоол, Шадар сайдын 120 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 4 алба хаагч, 1 нэгж техниктэй ажлын хэсэг 2019 оны 04 дүгээр сарын 25, 26-ны өдрүүдэд Алтанцөгц, Ногооннуур сумдад ажиллаж гамшгийн эрсдэлийн тойм судалгаа хийсэн.

Хоёр. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт сурталчилгааны талаар

Монгол Улсын Шадар сайдын баталсан “Үйлдвэрлэлийн барилга байгууламжид хяналт шалгалт явуулах тухай” төлөвлөгөөт, Онцгой байдлын газрын даргын баталсан “Алтанцөгц суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт-шалгалт явуулах тухай” төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн нийт 3 удаагийн удирдамжийн дагуу Гамшгаас хамгаалах болон Галын

аюулгүй байдлын тухай хууль, норм стандартын хэрэгжилтийг хангуулах хяналт-шалгалтыг 32 аж ахуйн нэгж, байгууллагад зохион байгуулж, нийт 224 зөрчил илрүүлэн 150 зөрчлийг газар дээр нь арилгуулж бусад зөрчлийг арилгуулахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 30, мэдэгдэл 2-ийг тус тус хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийн хугацааг сунгуулахаар хүсэлт гаргасан 12 иргэний материалыг хүлээн авч, тухайн объектуудад хяналт-шалгалт явуулж, галын аюулгүй байдлын норм, стандартыг хангасан 12 объектод галын аюулгүй байдлын дүгнэлт олгов.

Аймгийн Засаг даргын “Барилга байгууламж улсын комисст хүлээж авах” ажлын хэсэг байгуулах тухай 1 удаагийн захирамжаар барилга байгууламж хүлээж авах улсын комисст орж ажиллан Буянт сумын “Дулааны гадна байгууламж”-ийг улсын комисст хүлээж авсан.

Өлгий сумын 5-р багт шинээр баригдах иргэний 15 айлын орон сууцны, Улаанхус сумын 3-р багт баригдах 125 хүүхдийн цэцэрлэгийн, Ногооннуур сумын 4-р багийн төвийн барилгын ажлын зургийг тус тус хянаж, зураг төсөвт магадалгаа хийсэн.

Галын аюулгүй байдлын дүгнэлт, зураг төсөвт магадалгаа хийсэн улсын тэмдэгтийн хураамж 387,000 /гурван зуун наян долоон мянган/ төгрөгийг төрийн сангийн холбогдох дансанд төвлөрүүлсэн.

Гурав. Аюулт үзэгдэл, ослын дуудлагаар ажилласан талаар.

3.1 Объектын гал түймрийн талаар: 2019 оны 5 дугаар сард ой, хээрийн гал түймрийн 1, объектын гал түймрийн 3 нийт 4 удаагийн дуудлагатай байлаа. Үүнээс: Анги унтраасан 4 байна.

	Дуудлагын тоо	Зарцуулсан			Хүч			Хугацаа			Аварсан			Хохирол	
		Шатахуун /л/	Хөөс /л/	Ус /тн/	1 тасаг	2 тасаг	2-оос дээш тасаг	30 минут	30-60 минут	60-аас дээш	Хөрөнгө /сая/	Байшин , гэр	Хүн	Том хүн	Хүүхэд
Нийт	4	121	-	15	4	-	-	3	-	1	156	3	-	-	-

3.2 Эрэн хайх, аврах ажиллагааны талаар: 2019 оны 5 дугаар сард гамшиг, аюулт үзэгдлийн 1 удаагийн дуудлага ирсэн. Үүнд: Онцгой байдлын газраас ажилласан -1.

	Дуудлагын тоо	Шатахуун /тн/	Хүн, хүч					Аварсан			Хохирол				
			ЭХАБ 1 тасаг	Бэлтгэл ээлж	Сумын мэргэжлийн анги	Техник	Хүн	Цаг	Хүн	Техник	Хөрөнгө/ сая/	Том хүн	Хүүхэд		

Нийт	1	5,8	54	34	33	307	144	-	-	-	2	-
------	---	-----	----	----	----	-----	-----	---	---	---	---	---

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

4.1. Эрүүл мэндийн чиглэлээр

4.1.1. Нийгмийн эрүүл мэндийн төвийн (НЭМТ) ажлын талаар

“Эрүүл хүнс” сарын аяны хүрээнд 4 дүгээр сарын 22-ноос 5 дугаар сарын 18-ны өдрийг хүртэл мэргэжилтнүүд 13 сум 1 тосгон, аймгийн төвийн 13 багт ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллав.

Нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах, дархлаажуулалтын бичил төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд 5 дугаар сарын 13-ны өдөр Сум дундын эмнэлэг, сум, тосгоны болон өрхийн Эрүүл мэндийн төвийн дарга, эрхлэгч нар, вакцинаруудад 1 өдрийн сургалт зохион байгуулж, холбогдох мэдээллийг өгч, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.

Дархлаажуулалтын 10 хоногийн аяны нээлтийн үйл ажиллагаа Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Эрүүл мэндийн газрын санхүүжилтээр 5 дугаар сарын 16-ны өдөр аймгийн Спорт цогцолборт зохион байгуулагдсан. Нээлтийн үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Засаг даргын тамгын газрын боловсролын асуудал хариуцсан мэргэжилтэн, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, сургууль цэцэрлэгүүдийн төлөөллүүд, 5-18 насны хүүхдүүд, эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд оролцож, сургалт сурталчилгааны материал тараагдаж, радио телевизээр дархлаажуулалттай холбоотой мэдээлэл хийгдсэн.

5 дугаар сарын 15-25-ны өдрүүдэд “Улаанбурхан өвчинд цэг тавья” уриан дор аян зохион байгуулж, уг аяны хүрээнд аймгийн хэмжээний 5-18 насны 29735 хүүхдүүдээс нийт 28289 хүүхдийг вакцинжуулалтад хамруулж, хамрагдалт 95,1%-тай байна.

Сүрьеэгийн тасагт эрчимт эмчилгээний хугацаа нь дууссан 5 өвчтөнийг Толбо, Дэлүүн, Улаанхус сумын Эрүүл мэндийн төвүүд, Мейрим, Раушан ӨЭМТ-үүдэд үргэлжлэх шатны эмчилгээ хийлгэхээр гурвалсан гэрээгээр шилжүүлсэн.

5 дугаар сарын 14-ний өдөр аймгийн ЭМГ, Зоонозын өвчин судлалын төвийн дарга нар орон нутгийн “Дербес”, “Саян” телевизээр болон радиогоор Тарваган тахал өвчний өнөөгийн байдал, хийгдэж байгаа тандалт судалгаа, урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ, мэдээлэл, ярилцлага өгч ажилласан.

2019 оны 5 дугаар сарын 14-нөөс 6 дугаар сарын 10-ны өдрүүдэд аймгийн төвийн бүх бүрэн дунд сургуулиудад Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны графикчилсан төлөвлөгөөг гарган аймгийн төвийн 9 сургуулийн 6200 сурагчдыг, мөн Бугат, Дэлүүн сумын бүрэн дунд сургуулийн сурагч, ЗДТГ-ын удирдлагын ажилтан албан хаагч нарыг хамруулж сургалт хийж, зурагт хуудас тарааж ажилласан.

Голомтот сумдыг хариуцсан голомтын бага эмч нар зоонозын халдварт өвчин, тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа хийж, Улаанхус,

Сагсай, Бугат, Ногооннуур, Дэлүүн сумдын нийт 3000 гаруй хүнийг хамруулж, 2500 ширхэг гарын авлага, санамж хуудас тараасан.

5 дугаар сарын 21-ний өдөр ОХУ-ын Ташантад Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, голомтын тандалт, судалгааны чиглэлээр дадлага сургуулилтад ЭМГ, ЗӨСТ-ийн дарга нар болон мэргэжилтнүүд оролцов.

Зоонозын өвчин судлалын үндэсний төвөөс ирүүлсэн 3000 хүн тун тарваган тахлын эсрэг вакциныг хүлээн авч, дархлаажуулах үйл ажиллагааг Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу 7 дугаар сард хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Мөн Жансая, Рауан ӨЭМТөвүүдэд аймгийн ЗӨСТөвийн мэргэжилтнүүд хяналт үнэлгээгээр очиж тарваган тахлын бэлэн байдлыг шалгаж, тарваган тахлын өмсгөлийг дадлага хэвшүүлэх сургалт хийж, тусгаарлах өрөөнүүдийн бэлэн байдал, Эрүүл мэндийн сайдын тушаалын хэрэгжилт зэргийг үзэж эмч, эмнэлгийн ажилчдад арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

4.1.2. Эмнэлгийн тусламжийн хэлтсийн ажлын талаар

“Эрүүл шүд – Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөр хэрэгжиж байгаатай холбогдуулан “Азу-тис”, “Санди-тис”, “Хосхүү-дент”, “Ахмеруерт”, “Маржан” зэрэг хувийн шүдний эмнэлгүүдэд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, аймгийн ЭМГ хамтарсан хяналт үнэлгээг 5 дугаар сарын 7-8-ны өдрүүдэд хийж арга зүйн зөвлөгөө өгч, мэдээллээр хангав.

Ногооннуур, Дэлүүн сумуудын Сум дундын эмнэлэг, Алтай, Буянт, Толбо сумууд, Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төвүүдэд аймгийн ЭМГ-ын мэргэжилтнүүд дэмжлэгт хяналт үнэлгээ хийсэн.

4.1.3. Зоонозын өвчин судлалын төвийн (ЗӨСТ) ажлын талаар

ЗӨСТөвийн 2019 оны календарьчилсан төлөвлөгөөний дагуу Хачигт халдварын байгалийн голомтын тандалт судалгааг 2019 оны 4 дүгээр сарын 25-наас 5 дугаар сарын 5-ны хүртэлх хугацаанд аймгийн Улаанхус сумын Битүү, Хар уул, Хүрэнгийн уул, Сагсай сумын нутаг Дунд уул, Модон хөшөө, Алтанцөгц сумын Тогтоогийн уул зэрэг газруудыг хамруулан эрсдэлт бүлгийн иргэнээс мэдлэг хандлага эрсдэлийг үнэлэх зорилгоор хүн амын дундах асуумж, судалгааг авч, бэлчээр болон малаас 150 гаруй хачиг цуглуулж, 37 хүнээс цус, цусны ийлдэс цуглуулж, ЗӨСҮТөвийн лавлагаа лабораторид онош шинжлүүлэхээр илгээсэн.

5 дугаар сарын 20-ны өдөр аймгийн Онцгой байдлын газрын нийт 53 албан хаагчдыг хачигт энцефалит вакцинжуулалтад бүрэн хамруулсан.

Тарваган тахал өвчнөөс сэргийлэх чиглэлээр Дарын цогцолбор сургууль, ЕБ-ийн 4 дүгээр сургуулийн сурагчдад “Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ” авах сэдэвт сургалт хийж, нийт 2000 гаруй сурагчийг хамруулан мэдээ мэдээлэл өгч ажилласан.

Хачигт халдварын сэжигтэй 14 хүнээс сорьц дээжлэн, зохих журмын дагуу халдвар ЗӨСҮТөвд онош тодруулах шинжилгээ хийлгэхээр илгээсэн.

Аймгийн ЗӨСТ-ийн холбогдох мэргэжилтнүүд “Баян-Өлгий аймгийн хачигт халдварын тандалт судалгааны асуудал” сэдвээр эрдэм шинжилгээний илтгэл бичиж “Зоонозын халдварын тулгамдсан асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулагчдад илгээсэн ба редакцийн зүгээс уг илтгэлийг номонд хэвлэж, ханын илтгэлээр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Хачигт халдварын хүн амын дундах тандалт судалгаанд ЗӨСТ-ийн лаборант ажиллаж, Сагсай сумаас 14, Улаанхус сумаас 10, Алтанцөгц сумаас 13, нийт хачигт халдварын эрсдэлд өртсөн 37 хүний ийлдэс цуглуулж ЗӨСҮТөвд шинжлүүлэхээр илгээсэн.

ТАВ.ХӨДӨӨ, АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, БОАЖУулчлалын Сайдын 2019 оны 04 тоот албан даалгавар, аймгийн Засаг даргын 2019 оны захирамжийн хүрээнд бүх нийтээр мод тарих сарын ажлын арга хэмжээнд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын хамт олон амжилттай оролцлоо.

Оны эхний төллөвөл зохих 914738 толгой хээлтэгчээс 753872 толгой хээлтэгч төллөж, 726604 толгой төл хүлээж авсан. Төл бойжилт 96,3%, мал төллөлт 82,4%-тай байна.

Тус сарын байдлаар 38736 толгой мал зүй бусаар хорогдож, оны эхний малын 1,8% хорогдсон мэдээтэй байна.

Мөн бэлчээрийн хөнөөлт царцаатай тэмцэх ажлын гэрээг ХХААХҮЯамны МААБХЗГазартай байгуулсан.

2019 онд аймгийн хэмжээнд ээмэгжүүлэх хээлтүүлэгч болон цөм сүргийн малын тоо,судалгааг гаргаж, ээмэгний захиалгыг ХХААХҮЯ-д өгч, мал ангилалтын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

“Эрүүл хүнс” сарын аяны ажлын хүрээнд аймгийн Засаг даргын захирамжийн дагуу аймгийн ТЗУХ-ийн даргаар ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гарч, аймгийн төвийн 209 аж ахуйн нэгж болон иргэдийн үйлчилгээ явуулж байгаа дэлгүүр, гуанзнуудын үйл ажиллагаанд хяналт-шалгалт хийж, шаардлага хангаагүй аж ахуйн нэгж болон иргэдэд зөвлөгөө өгч, арга хэмжээ авч ажиллав.

“Сум хөгжүүлэх сан”-гийн өнөөгийн байдлыг дүгнэн цаашид авах арга хэмжээний санал боловсруулах, сангийн үр өгөөжийг дээшлүүлэх, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор 2019 оны 5 дугаар сарын 9-ний өдрөөс ажлын 20 хоногийн хугацаанд Сангийн сайд болон ХХААХҮ-ийн сайдын хамтарсан ажлын удирдамжийн дагуу аймгийн Засаг даргын 2019 оны А/323 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг үзлэгийг хийж гүйцэтгэв.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох хөнгөлөлттэй зээлийн материалуудыг хүлээн авах зарыг олон нийтэд хүртээмжтэй байлгах зорилгоор орон нутгийн бүх хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон байгууллагын веб сайтаар дамжуулан хүргэсэн.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах дэд хороог аймгийн Засаг даргын 2019 оны А/389 дугаар захирамжаар байгуулсан.

Тус онд төмс 300 га, хүнсний ногоо 140 га, малын тэжээл 1053 га, жимс жимсгэнэ 94 га, нийт 1588 га-д тариалалт хийхээс 5-р сарын байдлаар төмс 200 га, хүнсний ногоо 72 га, малын тэжээл 400 га, жимс жимсгэнийг 85 га-д тариалаад байна.

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

6.1. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр

Хууль бус тарвага, шувуу агнах, барих шувууны өндөг түүх зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын удирдамж батлуулан, удирдамжийн дагуу аймгийн Цагдаагийн газартай хамтран Ногооннуур, Бугат сумдын газар нутагт шалган сурталчлах ажлыг зохион байгууллаа.

Аймгийн БОАЖГазар, МХГазар, Бугат сумын ЗДТГазар, хамтран Байгаль орчны тухай багц хууль, Усны тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Бугат сумын хууль бус хайраг олборлож байсан газар нутагт эргүүл постыг 2019 оны 3 дугаар сарын 26-наас 6 дугаар сарын 1-ний өдөр хүртэл ажиллуулж байна.

Аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн хайгуул, олборлолт, үйлдвэрлэлтийн холбоотой үйл ажиллагаанаас үүсэж буй хог хаягдлын талаарх сүүлийн 3 жилийн статистик мэдээлэл болон аж ахуйн нэгжүүдийн Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний биелэлтэд тусгагдсан хог хаягдлын талаарх мэдээллийг нэгтгэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлээ.

БОАЖ-ын сайдын санаачлагаар “Хандлагаа өөрчилъе” уриан дор “Ногоон паспорт-Монгол орон даяар” аян өрнөж байгаатай холбогдуулан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Боловсрол, соёл, урлагийн газартай хамтран 12 сумын ЕБС-ын Эко клубийн ногоон паспорт, эзэмшигч сурагчдад ногоон паспортын ач холбогдол болон зөв дадал хэвшлийг бусдад түгээн дэлгэрүүлэх, ногоон паспортын хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээний талаар ойлголт өгөх, сум тус бүрээс хамгийн сайн хөтөлсөн нэг сурагчийн ногоон паспортыг шалгаруулах зэрэг ажлуудыг танилцуулан, сургалт зохион байгуулж ажиллалаа.

“Шийдэл сан” ТББайгууллага, Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран Алтайн Таван Богдын ТХГ-ын Ойгор болон Цагаан голд Финланд улсын GT-330 маркийн 3 ширхэг эко жорлон байршууллаа.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасны дагуу ургамал, ус, рашаан, ой, ан амьтан, газрын нөөц ашигласны төлбөрийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтын тайланг сум тус бүрээр 2016-2018 оны байдлаар гаргаж БОАЖЯаманд хүргүүлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн тавдугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гарагийг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” хэмээн зарласантай холбогдуулан хаврын мод тарих өдөрлөгийг аймгийн Засаг даргын А/332 тоот захирамжийн дагуу төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу сумдын ЗДТГазар, Сум дундын ой ангитай хамтран 2019 оны 05 дугаар сарын 18-ний өдөр зохион байгууллаа. Уг арга хэмжээнд аймгийн хэмжээнд 8 төрлийн 4800 гаруй ширхэг мод таригдсан.

6.2. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр

“Газрын харилцааны ажилтны өдөр” 65 жилийн ойг тохиолдуулан Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас зохион байгуулж буй урлаг, спортын арга хэмжээнд тус байгууллагын мэргэжилтнүүд идэвхтэй оролцсон.

2019 оны 04-р сарын 30-ны өдөр Төрийн ордны их танхимд Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоо хамтран зохион байгуулж буй "Геодези,

зураг зүйн салбарын ажилтны II зөвлөгөөн"-д байгууллагын газрын даргатай геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн оролцов.

Өлгий хот дотор шинээр тавигдах 10,4 км засмал зам дагуу байрлалтай иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын зөрчилтэй газруудыг чөлөөлүүлэх хугацаат мэдэгдэх хуудсыг өгч ажиллаа.

Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 5 иргэнд газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож гэрээ байгуулан холбогдох өөрчлөлтийг улсын бүртгэлд тусган мэдээллийн санд оруулсан болно. Мөн “Өлгий ланд”, “Эл-эм ланд” ХХК-ийн хийсэн 31 газрын хэмжилтийн мэдээллийг хүлээн авч кадастрын мэдээллийн санд тус тус орууллаа.

Сумдын даамлуудын үйлдэж өгсөн 12 газрын кадастрыг хянаж бүртгэлд оруулав.

6.3. Уул уурхайн чиглэлээр

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн 1 аж ахуйн нэгжийн хүсэлтийг Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын хэлтэст хүргүүлэн зураг зүйн шүүлт хийлгүүлэв.

6.4. Ус, цаг уур, орчны шинжилгээний чиглэлээр

Цаг агаарын урьдчилсан мэдээллийг аймгийн радио болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан ард иргэдэд түгээв.

Мөн 5 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээг холбогдох газруудад цахим хэлбэрээр хүргүүлэв.

Байгууллагын дарга, бичиг хэргийн эрхлэгч нар АЕГазраас зохион байгуулсан цахим хуралд оролцов.

5 дугаар сарын 12,13-ны өдрүүдэд цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг хийсэн ба Өлгий, Булган сумдад 1,0мм, Баяннуур суманд 5,0мм, Буянт суманд 00мм, Даян багт 3,5мм, бусад сумдын нутгаар уулаараа хур тунадас орсон.

Тус сард хоногийн урьдчилсан мэдээг 31 удаа, нарийвчилсан урьдчилсан мэдээг 31 удаа, климат мэдээг 1 удаа, 2019 оны 6 дугаар сарын урьдчилсан мэдээг 1 удаа тус тус зохиож төврүү дамжуулж, зохих газруудад хүргүүлэв.

6.5. Дэд бүтцийн чиглэлээр

6.5.1. Цахилгаан хангамжийн талаар

Аймгийн хэмжээнд Баруун бүсийн эрчим хүчний системээс 13182.0 мян.кВ.цаг цахилгааныг худалдан авч, 11202.0 мян.кВ.цаг цахилгаан худалдан борлуулсан. Нийт 1980.0 мян.кВ.цаг цахилгааныг шугамд алдсан. Нийт алдагдал 15.0%-тай байгаа. Худалдан борлуулсан цахилгаанд 1439.0 сая төгрөгийн нэхэмжлэл бичиж, 1426.0 сая төгрөгийг цуглуулсан. Борлуулалтын орлого 99%-ийн цуглуулгатай байна.

6.5.2. Холбооны талаар

Тус газар нь 2019 оны 5 дугаар сард шуудангаар болон мэйл хаягаар компаниас 3, орон нутгийн бусад байгууллагаас 15, нийт 18 албан бичгийг хүлээн авч тухай бүр бүртгэл хөтлөн, байгууллагын удирдлагад танилцуулан холбогдох албан тушаалтнуудад шилжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Мөн газрын үйл ажиллагааны асуудлуудаар албан байгууллагад 18 албан бичиг боловсруулан хүргүүлж хариу, шийдвэр гаргуулж ажиллав.

Ажиллагсдын ажлын хариуцлага, сахилгыг дээшлүүлэхэд анхаарч ажлын цагийг цаг бүртгэлийн төхөөрөмжөөр бүртгэж, хүн бүрт өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг эргэж мэдээлдэг, ажлынхаа үр дүнг сар бүр дүгнүүлдэг зэргээр ажлыг шинэлэг хэлбэрээр зохион байгуулан ажиллаж байна.

Улс, хот хоорондын сүлжээний бэлэн байдлыг хангаж, орон нутгийн иргэд, албан байгууллагууд мэдээ, мэдээллийг цаг тухай бүр, шуурхай хүлээж авах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд онцгой анхаарч аймаг, сумын шилэн кабель, кабель шугамын үзлэг, үйлчилгээг тогтмол чанартай хийж, гарсан гэмтэл саатлыг шуурхай илрүүлэн засаж, зөрчлийг арилгах арга хэмжээг байнга авч ажилласны дүнд сүлжээнд саатал гараагүй болно. Тайлант сард үндсэн SDH төхөөрөмжөөс ямар нэгэн гэмтэл саатал гараагүй болно.

6.5.3. Аймгийн радио телевизийн сүлжээний ажлын талаар

Сар бүр ажилчдын хурал, долоо хоног бүр чанарын хурлыг тогтмол хийж, тухай бүр ажлаа дүгнэж байна.

Радио болон тоон телевизийн станцуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, гарсан гэмтэл саатлыг шуурхай засварлаж, сар бүр үзлэг үйлчилгээ хийж байна.

Сумууд дахь тоон ТВ-ийн тоног төхөөрөмжүүдэд гэмтэл саатал гараагүй хэвийн ажиллаж байна.

6.5.4. Усны талаар

Байгууллагын статистикийн сарын мэдээг гаргаж Статистикийн хороонд хүргүүлэв.

Авлагатай аж ахуйн нэгж, байгууллагуудад мэдэгдэх хуудас тарааж, авлага цуглуулах арга хэмжээ авч ажилласан. Мөн авлагаа барагдуулах талаар орон нутгийн радиогоор ард иргэд, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл хүргэж ажиллав.

Химийн бодисын зарцуулалтын тайланг гаргаж, холбогдох газруудад хүргүүлэв.

6.5.5. Авто тээврийн талаар

Энэ сард техникийн хяналтын үзлэгт нийт 1397 тээврийн хэрэгсэл хамаарагдсанаас суудлын тээвэр 861, ачааны тээвэр 286, автобус 56, тусгай 11, механизм 8, чиргүүл 16, мотоцикл 159 тус тус бүртгэгдсэн байна. Нийт өссөн дүнгээр тэнцээгүй тээврийн хэрэгсэл- 5 бүртгэгдсэн.

Улс хоорондын Өлгий-Алмата хотын чиглэлд орчин үеийн АЕРО, ЮТИОНГ том оврын автобуснуудаар зорчигч тээвэрлэх, шинээр рейс нээх ажлууд явагдаж байна.

Хот хоорондын чиглэлд “Газрын Од” ХХК-ийн том оврын 24 АЕРО автобус, “Цэнгэлтранс” ХХК-ийн том оврын 15 АЕРО автобус, нийт 39 тээврийн хэрэгслээр хот хоорондын байнгын үйлчилгээнд зорчигч тээвэрлэж байна.

Энэ сард хот хооронд явсан зорчигчдын тоо 2540, рейсийн тоо 61 байна. Нийт Казахстан улс руу автобусаар явсан зорчигчдын тоо 265, рейсийн тоо 8 байна.

ДОЛОО. СУМ, ОРОН НУТГИЙН ТАЛААР

1.ӨЛГИЙ СУМ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын ажлын талаар

Тавдугаар сард тус сумын Засаг даргаас нийт 23 захирамж гарч хэрэгжилтийг хангуулан ажиллав.

Ард иргэдээс 29 өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх шатандаа байна.

Иргэний бүртгэлээр тухайн сард 416 хүнд үйлчилгээ үзүүлснээс:

- Төрөлт	102
- Гэрлэлт	15
- Нас баралт	15
- Гэр бүл цуцлалт	2
- Үрчлэлт	4
- Дахин олголт	0
- Цахим үнэмлэх олголт	12
- Шилжих хөдөлгөөн	
- Ирсэн	35
- Явсан	0
- Овог нэр, нэр өөрчлөлт	4
- Эцэг тогтоолт	1
- Иргэний шинэчилсэн бүртгэлд	127
- Лавлагаа	25
- Харьяалал харгалзахгүй бүртгэлд	74 иргэн тус тус хамрагдсан байна.

Хоёр. Захирагчийн ажлын алба, дэд бүтэц, худалдаа, үйлчилгээний талаар

Бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнд идэвхтэй оролцсон.

Аймгийн Засаг даргын захирамжаар зохион байгуулсан “Эрүүл хүнс” сарын аяны хүрээнд Өлгий суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, албан байгууллагуудын нийтийн хоолны газар болон худалдаа, үйлчилгээний цэг салбаруудад мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулан хяналт шалгалтыг үр дүнтэй явуулсан болно.

2019 онд ОНХСангийн санхүүжилтээр хийгдэх бүтээн байгуулалтын ажлын газрын сонголтыг хийж, зураг схемийг гарган, төсөв хийлгэх талаар холбогдох байгууллагад хүргүүлсэн.

2020 онд ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх бүтээн байгуулалтын ажлын талаар иргэдээс авсан саналыг эрэмбэлэв.

Өлгий сумын ЗДТГазрын төрийн жинхэнэ албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулав.

Энэ онд ОНХСангийн хөрөнгөөр 5-р багт тавигдсан гудамжны гэрэлтүүлгийн ажлыг ашиглалтад хүлээж авлаа.

Ойрын жилүүдэд Өлгий хотод хийгдэх шаардлагатай бүтээн байгуулалтын ажлуудын саналыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлэв.

Гурав. Хууль, эрх зүйн үйл ажиллагааны талаар

Төрийн албаны тухай хууль шинэчлэгдсэнтэй холбогдуулан албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсэгтэй хамтран ажиллав.

Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу “Эрүүл хүнс” сарын аяны хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл,

урлагийн газартай хамтран Өлгий сумын 1, 2, 3 дугаар багуудад хяналт-шалгалт хийсэн болно.

5 дугаар сард гарсан хүчирхийлэл, хүүхдийн хөгжлийн мэдээг нэгтгэж аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлэв.

Дөрөв. Мал эмнэлэг, үржлийн тасгийн үйл ажиллагааны талаар

Хөдөө аж ахуйн салбартай холбоотой судалгаа, хөдөлмөрийн биелэлт, графикт мэдээнүүдийг холбогдох газруудад тухай бүр гаргаж өгсөн.

Сумын төвийн сүүний чиглэлийн 12 фермд хяналт-шалгалт хийж зааварчилгаа, зөвлөгөө өгч 105 толгой үхэр сүрэгт үзлэг хийв.

Хаврын тариалалтын бэлтгэл ажлыг хангуулж 58 өрхийн тариалалтыг хийлгэв.

Сум хөгжүүлэх сангаас зээл авсан 23 иргэний хэргийг шүүхэд шилжүүлсэн бөгөөд 11 хүний 18.0 сая төгрөгийн зээлийг бүрэн төлүүлсэн.

Аймгийн Статистикийн хэлтэст том малын зүй бус хорогдол болон мал төллөлт, бойжилтын тухайн сарын мэдээг гаргаж хүргүүлэв.

Тав. Нийгмийн бодлогын талаар

Өлгий сумын хэмжээнд дугуйн спортыг хөгжүүлэх зорилгоор Эх үрсийн баярыг тохиолдуулан 2019 оны 5-р сарын 25-ны өдрийн 10:00 цагт Өлгий сумын Засаг даргын нэрэмжит унадаг дугуйн уралдаан зохион байгуулав. Уг арга хэмжээний нээлтэд Өлгий сумын Засаг дарга оролцсон бөгөөд Өлгий сумын хэмжээнд дугуйн спортыг хөгжүүлэх, дугуйн спорт сонирхогчдын тоог нэмэгдүүлэх, залуучуудын дунд өрсөлдөн бий болгож ур чадварыг дээшлүүлэх, цаашид улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг, тамирчдыг сонгон шалгаруулахад энэхүү тэмцээний зорилгоо оршино.

Аймгийн Засаг даргын санаачилгаар зохион байгуулж буй “Эрүүл Хүнс” сарын аяны хүрээнд мэргэжлийн байгууллагуудтай хамтран Өлгий сумын харьяа сургууль, цэцэрлэгүүдийн гал тогооны ажилтан нар болон үдийн цай өгдөг аж ахуйн нэгжүүдийн төлөөллүүдийг оролцуулан хяналт-шалгалтын ажлыг хийв. Уг арга хэмжээнд нийт 150 гаруй хүн оролцов.

Аймгийн ЗДТГазраас тухайн сард зохион байгуулсан “Нутгийн захиргааны байгууллагуудын жендерийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах” сургалтад оролцов.

Аймгийн Номын сантай хамтран ажиллах зорилгоор явуулын номын сан ажиллуулан ажилчид, албан хаагч нарт 2 сарын хугацаанд нийт 36 номыг тарааж өгч үйлчилгээ үзүүлсэн.

Зургаа. Санхүүгийн албаны талаар

Өлгий сумын ЗДТГ, сургууль, цэцэрлэгүүдийн 5 дугаар сарын санхүүжилтийг олгож баталгаажуулав.

Өдөр тутам хийгдсэн гүйлгээний дансны хуулгыг гаргаж баримтыг тулган боловсруулж мемориал болгон үдэж хадгалав.

Дөрөвдүгээр сарын шилэн дансны мэдээг 100% оруулсан.

Өлгий сумын 13 багийн Засаг дарга нарт ХАӨМС-д байгаа ургийн овог, нас барсан иргэдийг мэдээллийн сангаас хасах, шинээр төрсөн хүүхдүүдийг бүртгэх,

ерхийн бүх алдааг засах, гадаадад амьдарч байгаа хүмүүсийн мэдээллийг тодруулахыг зааварчлав.

Долоо. Байгаль орчин ариун цэврийн талаар

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар жил бүрийн тав, аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гаригийг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” хэмээн зарласантай холбогдуулан 2019 оны 5 дугаар сарын 18-ний өдөр "СУАТ" ХХК-ийн хашаанд байгууллагууд мод тарив. Зарим байгууллагууд өөрсдийн байгууллагынхаа хашаанд мод тарьсан болно. Бүх нийтээр мод тарих өдрөөр нийтдээ 1890 ширхэг мод тарьсан.

“Тирлик” захад Чихэр өвсний үндсийг худалдаалж байгаа талаар аймгийн БОАЖГазрын ахлах мэргэжилтнээс ирсэн мэдээллийн мөрөөр байгаль хамгаалагчид шалгалт хийж 50 ширхэг чихэр өвсний үндсийг хураан авч улсын байцаагчид хүлээлгэж өгсөн болно.

Өлгий сумын байгаль хамгаалагч Х.Сулушаш 2019 оны 5 дугаар сарын 14-ний өдөр Аймгийн радио /9 цагийн мэдээ/-гоор “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”, Ховд голын эргийг хамгаалах, хог хаяхгүй байх, загас барих хориотойг ард иргэдэд сурталчлан мэдээлсэн.

2. ТОЛБО СУМ

Нэг. Удирдлага зохион байгуулалт, хууль, эрх зүйн чиглэлээр

5 дугаар сарын 1-ний өглөө 08:00 цагт сумын Онцгой комисс, Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг шуурхай цуглуулж аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай А/318 тоот захирамжийг танилцуулан үүнтэй холбоотой бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай сумын Засаг даргын А/29 тоот захирамжийг гаргаж цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэж төлөвлөгөө боловсруулан ажиллахаар шийдвэрлэв.

Уг төлөвлөгөөний дагуу тээврийн хэрэгслийн хөл хорио тогтоож, уулзварт 24 цагийн эргүүл гарган ажиллуулав. Өндөржүүлсэн бэлэн байдлын үеэр холбогдох хууль журмыг сахиж ажилласны үр дүнд ямар нэгэн зөрчил дутагдал гараагүй болно.

Сумд шинээр байгуулагдсан Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүдэд үүрэг даалгавар өгч, сумын төвийн эргэн тойрон болон нүүх цөөрөмд орж үхсэн малын сэг зэмийг зайлуулах ажлыг зохион байгуулав.

Цаг үеийн байдалтай холбоотой байгууллагын дарга эрхлэгчид, Тамгын газрын албан хаагчдын хурлыг 2 удаа зохион байгуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу байгууллага, айл өрх бүрт бүх нийтээрээ мод тарих, мөн загасны хяналтад гарах ажлыг сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нартай хамтран зохион байгуулав.

Хоёр. Татварын чиглэлээр

Д/д	Орлогын төрөл	Гүйцэтгэл
1	Улсын тэмдэгтийн хураамж	34100
2	Үйл ажиллагааны орлого	10000
3	Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	348170
4	Бууны албан татвар	120000

5	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0
6	Хүү торгууль	40000
7	Татварын бус орлого	-
8	Хадгаламжийн хүүгийн орлого	748409
	Дүн	1300679

Мөн 5 дугаар сарын 7-9-ний өдрүүдэд тус суманд зохион байгуулагдсан авто тээврийн үзлэг, оношилгоонд, сумын хэмжээнд байгаа авто техникийн хэрэгслүүдийг хамруулан татварыг зохих хууль журмын дагуу хурааж дуусгав. Үүнд: Тус сумаас 180 машины татвар болох 7,200,000 төгрөгийг төсөвт оруулав.

Гурав. Боловсролын талаар

Дэлхийн зөн ОУБ-ын санаачилгаар сурагчдын “Сэтгүүлч” клуб тус суманд үйл ажиллагаагаа явуулж байгаа ба уг клубийн 15 сурагч хамтран “Жаухазын” нэртэй сонинны анхны дугаарыг гаргав. Мөн Дэлхийн зөн ОУБ-аас багш, удирдах ажилтан, сурагчдын дунд сургалт зохион явуулав.

Аймгийн БСУГ-ын Монгол хэл хариуцсан арга зүйч тус сургуульд 3 хоног ажиллан багш нарын үйл ажиллагаатай танилцлаа. Мөн 12-р ангийн сурагчдын хэл бичгийн шалгалтад бэлтгэх явцтай танилцаж арга зүйн зөвлөгөө өгөв.

Бүх багш нар болон 5, 9, 12-р ангийн сурагчдаас аймгийн Засаг даргын нэрэмжит шалгалт авлаа. Уг шалгалтаас гарсан үнэлгээнд анализ хийж, үр дүнг тооцон ажиллаж байна.

Дөрөв. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр

Толбо сумын Цагдаагийн байгууллагатай хамтран “Хүүхэд хүмүүжлийн эерэг аргад суралцъя” уриан дор 100 ширхэг стикерийг сургуулийн дотуур байрны хүүхдүүдэд тарааж өгч, албан байгууллага, сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүүхдүүдэд сургалт сурталчилгаа явуулав. Мөн 12-р ангийн сурагчдад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай сургалт хийв.

Мөн тус сумын Цагдаагийн байгууллага, Байгаль орчны хяналтын улсын байцаагч болон сургуулийн Нийгмийн ажилтан нар хамтран 10, 11, 12-р ангийн сурагчдад “Байгалиа хамгаалъя” сэдэвт хурал зохион байгуулав.

Аймгийн ЗДТГ-ын Хурлын зааланд зохиогдсон “Нутгийн захиргааны байгууллагуудын жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтнийг чадавхжуулах” сургалтад оролцов.

Тав. Эрүүл мэндийн чиглэлээр

Тус сард байгууллагад ирсэн алсын дуудлага болон ойрын дуудлагад цаг тухайд нь эмч нарыг явуулан тусламж үйлчилгээ үзүүлж байв. Үүнд алсын дуудлагад нийт 34 удаа явж үйлчлэв.

Мөн “Эрүүл хүнс” сарын аяны хүрээнд төлөвлөгөө гарган ажиллав.

Аваар ослын тохиолдол нэг удаа бүртгэгдсэн ба тархи, толгойн хүнд гэмтэл авсан иргэнийг аймгийн Нэгдсэн эмнэлгээс ирсэн нарийн мэргэжлийн эмчид үзүүлсэн. Эх, хүүхдийн эндэгдэл гараагүй ба эх, хүүхдийн эргэлтийг стандартын дагуу хийлгэж байна.

Байгууллагын хурлыг 1 удаа хийж ажил үүргийн чиглэл өгөв.

Тус сард:

- Хэвтэн эмчлүүлсэн	-	71 хүн
- Ор хоног	-	497
- Бүх үзлэг	-	547
- Урьдчилан сэргийлэх үзлэг	-	196
- Амаржсан эхийн тоо	-	7
- Жирэмсний хяналтад хянагдаж байгаа эхийн тоо	-	69
- Үүнээс өртөмтгий бүлгийн жирэмсэн эх	-	10
- Шинээр хяналтад орсон	-	10
- Эсийн шинжилгээнд хамрагдсан	-	38
- Хөхний үзлэгт хамрагдсан	-	92 иргэнийг тус

тус бүртгэв.

Зургаа. Хөдөө аж ахуйн чиглэлээр

Том малын зүй бус хорогдлын мэдээ болон төл бойжилтын мэдээг долоо хоног болгон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлж байна.

Мал төллөлтийн мэдээ /5 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар/:

	Бүгд	Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа
Төллөсөн	50849	9	25	1025	36200	13590
Хорогдсон	1969	-	1	68	695	1205
Бойжсон	48880	9	24	957	35505	12385

Том малын зүй бус хорогдол /5 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар/:

	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Хорогдсон	5826	-	200	857	2415	2354

Долоо. Халамжийн үйлчилгээ болон хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр

2019 онд халамжийн сан улсын төсөвт шилжсэнтэй холбогдуулан тэтгэвэр, тэтгэмжийг чирэгдэлгүй ард иргэдэд хүргэх зорилгоор ажиллаж байна. Халамжийн тэтгэвэр, тэтгэмж болон бусад хөнгөлөлтийн санхүүжилтэд 4 дүгээр сард / давхардсан тоогоор/ 578 иргэнд 54 764 000 төгрөгийг сумын төрийн банк болон хаан банкаар дамжуулан олгож байна.

Үүнээс гадна ард иргэдийн хувийн хэрэг болон бусад өргөдөл, гомдлын дагуу өдөр бүр холбогдох материалыг шивж программд оруулж байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2015-2017 онуудад хамрагдсан малчдаас санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөх 68 хувийг төлүүлэв.

2019 онд малжуулах төсөл хөтөлбөрт 8 иргэн, ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрт 2 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 1 иргэнийг тус тус хамруулахаар сумын Амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлаар авч хэлэлцэн бичиг баримтуудыг нь холбогдох газарт хүргүүлсэн.

3. БУЛГАН СУМ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн Авто тээврийн төвтэй хамтран 2019 оны орон нутгийн авто тээврийн улсын үзлэгийг зохион байгуулж, бүх төрлийн авто техникийг хамруулав.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын байцаагчид тус суманд хүрэлцэн ирж өөр өөрсдийнхөө хариуцсан салбарт ажиллан зөрчил илрүүлж гарсан зөрчил, дутагдлыг хэрхэн арилгаж, хууль журмын дагуу хэрхэн ажиллах талаар арга зүйн зөвлөмж өгч ажиллав.

Аймгийн Онцгой байдлын газрын сургагч багш, мэргэжилтнүүд сумын гамшгийн төлөвлөгөө болон эрсдэлийн төлөвлөгөө боловсруулах талаар сургалт зохион байгуулж, орон нутагт тохиолдож байсан гамшиг, аюулт үзэгдлийн талаар тойм судалгаа хийх ажлыг зохион байгуулав.

Тухайн сард бүх багуудын нийтийн хурлыг зохих хуваарийн дагуу зохион байгуулж, багийн нийтийн хурлаар цаг үеийн ажил болон зуслангийн асуудал зэрэг тулгамдсан асуудлуудыг хэлэлцүүлэн тодорхой шийдвэр гаргуулж ажилласан.

Хоёр. Төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Тухайн сарын төсөвт байгууллагуудын төсвийн санхүүжилт, дэмжлэг хугацаандаа ирж, бүх төсвийн байгууллагууд цалин болон бусад санхүүжилтийг бүрэн авсан.

Төсвийн 9 байгууллагын санхүүжилтэд нийт 1547575,6 мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

Гурав. Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд

Тухайн сард цаг агаар цасан шуургатай, хүйтэвтэр байсан нь мал аж ахуйн хаваржилтад ихээхэн хүндрэл учруулав.

5 дугаар 10,11-ний өдрүүдэд болсон цасан шуурганаар тус суманд хаваржиж байсан Ховд аймгийн Мөнххайрхан сумын болон тус Булган сумын хэсэг малчдын 570 гаруй толгой мал хорогдсон ба энэхүү цасан шуурга, цаг агаарын хүйтрэлтээр бүх багуудаас зохих хэмжээний мал хорогдож, хорогдлын тоо өнгөрсөн сараас нэмэгдсэн.

Тухайн сарын мэдээгээр 37902 хээлтэгч төллөж, 17991 толгой төл бойжсон байна. Төл бойжилт нь 89%-тай байна. 2238 толгой төл хорогдсон бол 2533 толгой том мал янз бүрийн шалтгаанаар хорогдсон.

Байгаль орчны хуулийн хэрэгжилтийн хяналт, шалгалт 4 объектод хийгдсэн. Мөн сумын хэмжээнд нийт 513 ширхэг мод суулгасан. Тухайн сард “ Байгалиа хамгаалъя” сарын аян болон “ Ариун цэврийн хяналт-ын аяныг тус тус зохион байгуулсан.

Дөрөв. Үйлдвэрлэл, үйлчилгээ, эрчим хүч, дэд бүтцийн бодлогын хүрээнд

Энэ сард сумын үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн ажил хэвийн байв.

Хаврын цасан болон шороон шуурганаар Цахилгаан эрчим хүч тасалдах, зам даваа хаагдах зэрэг ямар нэгэн хүндрэл гараагүй.

Өргөн хэрэглээний барааны үнэ, өртөгт гарсан онцын өөрчлөлтгүй хэвийн байв.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх дэд бүтцийн ажлуудын зураг, төсвийг хийлгэх, захиалагчийг тодруулах зэрэг ажлуудын бэлтгэлийг ханган ажиллаж байна.

Улсын хөрөнгө оруулалтаар баригдах, 17 тэрбум төгрөгийн өртөг бүхий Ёлтын бага сургуулийн комплектний барилгын ажил эхлээд байна. Гүйцэтгэгчээр “Чандмань Уушир” ХХК ажиллаж байна.

Тав. Эрүүл мэнд, спортын талаар

Тус сумын Эрүүл мэндийн төвд тухайн сард 7 эх амаржиж, 7 хүүхэд эсэн мэнд бойжиж байна. 7 эхийн төрөхийн ор хоног 57 ор хоног байв. Хяналтад 81 эх байна. Нас баралт 1 гарснаас эмэгтэй хүн байсан ба гэрт нас барсан байна. 0-1 насны хүүхдийн эндэгдэл гараагүй.

Эрүүл мэндийн төвд нийт 82 хүн хэвтэн эмчлүүлсний ор хоног 504 ор хоног байна. Халдварт бус өвчлөл 58 гарсан ба шинжилгээнд 28% нь хамрагдсан. Түргэн тусламжийн дуудлага 89 гарснаас 78 нь алсын дуудлага байв.

Нийт үзлэг 774 байснаас урьдчилан сэргийлэх үзлэгт 319, амбулаторын үзлэгт 455 хүн тус тус хамрагдсан.

Вакцинжуулалтад 1560 хүүхэд хамрагдсан. Сумын орон нутгийн давсан хэсгээс 3,0 сая төгрөг гаргаж, сумын 7 багийн иргэдийг аймгийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулав.

4. САГСАЙ СУМ

Нэг. Удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн бодлогын хүрээнд

“Эрүүл хүнс” сарын аяныг сумын Засаг даргын захирамжийн дагуу зохион байгуулж, аяны нээлтийн ажиллагааг Эрүүл мэндийн газрын дарга хийж, 80-аад иргэд оролцлоо. Тус аяны хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын газар, ЭМГ-ын ажлын хэсэг сумд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

ХХҮГазрын Нийтийг хамарсан ажлын хүрээнд сумын төв болон сум орчмын газар, Ховд, Тургын голын эрэгний хог хаягдлын арчилгаа цэвэрлэгээ, Өлгий - Сагсай хоорондын авто замын арчилгаа зэрэг ажилд сумын төвийн ажилгүй 15 хүнийг 7 хоног түр ажиллуулав.

Сум байгуулагдсаны түүхт 60 жилийн ойн бэлтгэл ажлыг хангаж байгаа бөгөөд зохион байгуулах комисс 2 удаа хуралдав.

Суманд авто тээврийн улсын үзлэг болж нийт авто техникийн 40% нь буюу 135 автомашин, 65 мотоцикл хамрагдлаа.

Аймагт тарваган тахал өвчин гарсантай холбогдуулан сумын Засаг даргын захирамж гарч 4 дүгээр сарын 30-наас 5 дугаар сарын 6-ны өдрийн 20.00 цаг хүртэл тус суманд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин, 5 дугаар сарын 1-нээс эхлэн сумын 6 газар /Сагсай-Өлгий хоорондын зам Бөхөнд, Сагсай, Тургын голын гүүр, Өмнө голын чиглэл, Ховд голын гарам, Битүү чиглэл/-т 24 цагаар хоногт 12 төрийн албан хаагчаар эргүүл пост, 2 албан хаагчаар хариуцлагатай эргүүл /төв штабт/ гарган тогтмол ажиллуулан, иргэдэд сэрэмжлүүлж, хөл хөдөлгөөнийг бүрэн хязгаарлаж ажиллав. Тус арга хэмжээнд сумын Гамшгаас хамгаалах сангаас 300 л бензин шатахуун зарцууллаа.

ОНХСангийн 600.0 мянган төгрөгийн хөрөнгөөр сумын ЗДТГ-ын эзэмшилд байгаа Улаан дэлийн доод услалтын системийн шуудуу, суваг, даланг сэргээн засуулж, талбайн усалгааг хангав.

Аймгийн ЗДТГ-ын ажлын хэсэг Сум хөгжүүлэх сангийн хэрэгжилт, зохион байгуулалт, сангийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжилтийн үйл явцад хяналт-шалгалт хийж СХСангийн хэрэгжилт 88%-тай дүгнэгдэв.

Сумын Засаг даргын захирамжаар Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг томилогдож, төлөвлөгөөг боловсруулж байна.

Улаан бурхан улаануудын өвчний нөхөн дархлаажуулалтын 10 хоногийн аяныг өрнүүлж, ЗДТГ-аас 60 л бензиний дэмжлэг үзүүллээ. Тус дархлаажуулалтад сумаас 5-18 насны 1831 хүүхэд хамрагдах ёстойгоос 1729 хүүхэд хамрагдаж, вакцинжуулалтад хамрагдалт 94.4%-тай байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор сумын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд нийт 474 ш мод тарилаа.

Шинжлэх ухааны академи, Археологийн хүрээлэнгийн 20 хүний бүрэлдэхүүнтэй баг Цагаан асгатад 5 дугаар сараас эхлэн нэг сарын судалгаа, шинжилгээний ажил хийж байна.

Дэлхийн Зөн Монгол ОУБ-аас 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний явцыг дүгнэж, 2020 онд хэрэгжүүлэх ажлыг хамтарч төлөвлөв.

Тус суманд 2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалт, аймгийн ОНХС-аар хийгдэх бүтээн байгуулалтын ажлын жагсаалтыг гаргаж, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтэст уламжлан хүргүүлэв.

Нотариатын үйлчилгээг 42 иргэнд үзүүлж, тэмдэгтийн хураамжид 107,850 төгрөг оруулав.

Иргэдээс ирсэн 11 төрлийн өргөдөл гомдлыг хүлээн авч, барагдуулах ажил зохион байгуулав. Ирсэн 51 бичгийг бүртгэж түүний мөрөөр ажил зохион байгуулж, 32 албан бичгийг холбогдох газруудад хүргүүлэв.

Сумын Иргэний бүртгэлд шинээр төрсөн 14, үрчлэлт 2, гэрлэсний 1, нас барсны 1, иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд 13, шилжин ирсэн 1, шилжин явсан 0, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд 3, газар өмчлөх бүртгэлд 5 бүртгэгдэж, 38 иргэнд цахим үнэмлэх шинээр олгогдсон.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Төсөвт байгууллагуудад тавдугаар сард ирсэн төсвийг холбогдох зардлын зүйл ангиудад хуваарилан зарцуулж байна. Энэ сард нийт 127,831,974 төгрөгийн 152 төрлийн гүйлгээ хийгдсэн.

Татварын орлогод 1,722,000 төгрөг оруулан, 5-р сарын төлөвлөгөөний биелэлт 59.7%-тай, улсын тэмдэгтийн хураамж 128.4 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлого 527.2 мянган төгрөгөөр тус тус дутуу биелэгдсэн байна.

Сум хөгжүүлэх санд 1,2 сая төгрөгийн зээлийг эргэн төлүүлсэн.

ЕБ-ын 1 дүгээр сургууль 87940.4 мянган төгрөгийн, ЭМТөв 17376.2 мянган төгрөгийн, Хүүхдийн цэцэрлэг 11161.6 мянган төгрөгийн, Даян бага сургууль 428.3 мянган төгрөгийн, ЗДТГазар 26884.0 мянган төгрөгийн, ИТХурал 1723,3 мянган төгрөгийн, нийт 146614.9 мянган төгрөгийн өртэй байна. Сар бүрийн төсөв дутуу ирж байгаа нь төсөвт байгууллагуудад өр үүсэхэд нөлөөлж байна.

Гурав. Хөдөө аж ахуй, газар тариалан, байгаль орчны бодлогын хүрээнд

Одоогийн байдлаар 67383 толгой мал төллөсөн ба үүнээс ингэ 38, гүү 1964, үнээ 3294, хонь 35114, ямаа 26973 байна. Бүгд 1430 толгой төл хорогдсон. Бүгд 65953 толгой төл бойжиж байгаа бөгөөд ботго 36, унага 1946, тугал 3245, хурга 34765, ишиг 25961 байна.

Хорогдсон том мал бүгд 1777 толгой байгаагаас адуу 70, үхэр 161, хонь 789, ямаа 757 толгой мал тус тус хорогдсон. Мал төллөлт 88.2%, төл бойжилт 97,9%-тай байна.

2011-2018 онуудад Сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдийг СХСангийн улсын үзлэгт хамруулсан. Нийт 81 зээлдэгчийн материалыг шалгаж, явуулж байгаа үйл ажиллагаатай танилцсан.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 2 төрлийн вакцинжуулалтад 9557 толгой малыг, Паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх боловсруулалт, тулгалтад 71740 толгой мал хамрагдсан.

Аймгийн Засаг даргын “Мал эмнэлэг ариун цэвэр, халдваргүйтгэлийн сарын ажил зохион байгуулах тухай” 2019 оны А/227 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор сумын Засаг даргын “Малын сэг зэмийг устгах тухай” А/35 тоот захирамжаар 21 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан сэг зэм устгах үйл ажиллагааг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 16 машин техник, ажлын хэсгийн гишүүд, ХХҮГ-ын нийтийг хамаарсан ажлын 15 хүн, хорогдсон малын эзэд болох 104 малчид нийт 140 хүн ажилласан. Баг бүр өөрсдөө ард иргэдийг оролцуулан айл өрхүүдийн хашаа, хорооны ойр орчин, бэлчээрт үхэж хорогдсон малын сэг зэмийг машинаар явж цуглуулан тусгай нүх ухаж халдваргүйжүүлэлтийн бодис цацаж сэг зэмийг шатааж нүхэнд хийж булсан. Даянгийн чиглэлд мөнхийн цэвдэгтэй газартай нүх ухах боломжгүй тул шатааж устгах арга хэмжээ авсан. Уг үйл ажиллагааг 6 багт явуулсан бөгөөд баг бүрт 1-2 газарт бүгд 9 газарт сэг зэмийг шатааж устган нүхэнд булаж хлорын шохой, Hi-Cop бодисуудаар ариутгал, халдваргүйжүүлэлт хийсэн. Сарын ажлын хүрээнд 54 хашаа хороо, 69040м² талбайд ариутгал халдваргүйтгэл хийгдэж, 995 сэг зэмийг устгасан.

Дөрөв. Боловсрол соёл, шинжлэх ухааны талаар

2018-2019 оны хичээлийн жилийн эцсийн багш нарын сурган хүмүүжүүлэх зөвлөгөөнийг хийж, хичээлийн жилийн тайланг хэлэлцэж, төгсөх ангийн сурагчдыг зөвлөгөөнд оруулав.

Үсэглэлийн болон хонхны баярыг тусгай хөтөлбөрийн дагуу зохион явуулав.

12 ангийн сурагчдаас Шилдэг төгсөгч, Тэргүүний төгсөгч нарыг тодруулж шагнаж урамшууллаа.

5-р ангийн сурагчдаас бүх хичээлээр түвшин тогтоох шалгалт авч, ирэх жил анги удирдах болон хичээл заах багш нарт нь хүлээлгэж өглөө.

Анги дэвших болон төгсөлтийн шалгалтын комиссыг байгуулж, шалгалтын хуваарь гарган мөрдөн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын нэрэмжит ээлжит шалгалтыг нийт багш, 12, 5-р ангийн сурагчдаас авч, дүнг нэгтгэн аймгийн БСУГ-т хүргүүлэв.

Сургуулийн нийт сурагчдыг улаанбурханы вакцинжуулалтад хамрууллаа.

Тав. Эрүүл мэнд, спортын талаар

Энэ сард 7 эх хөнгөрсөн. Эмнэлэгт 42 хүн 252 ор хоног хэвтэн эмчлүүлсэн. Дархлаажуулалтад 98 хүүхэд хамрагдсан. Одоо 103 жирэмсэн эх хяналтад байгаа ба эх, хүүхдийн эндэгдэл гараагүй. 36 удаа түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлээ.

Казахстан Улсад зохиогдсон Азийн аварга шалгаруулах Көкпар /Тулам булаацалдах тэмцээн/-ээс сумаас оролцсон Серикийн Женисбек 1-р байр, Аударыспах тэмцээнээс Наканы Наурызбек, Еликийн Өмирбек нар 2-р байр эзэлж шагнал хүртлээ.

Зургаа. Нийгмийн халамж, хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн талаар

НДСангаас олгох 5-р сарын өндөр насны тэтгэврийг 434 иргэнд 143,374,775 төгрөг, тахир дутуугийн тэтгэврийг 156 иргэнд 52,712,878 төгрөг, тэжээгч алдсаны тэтгэврийг 94 иргэнд 27,753,141 төгрөг, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг 5 хүнд 6,250,000 төгрөгийг тавьж олголоо.

Нийгмийн даатгалд шинээр сайн дураар даатгуулах 5 хүнтэй гэрээ байгуулсан.

Аж ахуйн нэгж, байгууллагууд НДШ-ийн 26.5 сая төгрөгийн өртэй гарч, эхний 5 сарын төлөвлөгөө тасарсан байна.

Амьжиргааг дэмжих зөвлөлийг 2 удаа хуралдуулж, 8 иргэний байнгын асаргааг шинээр тогтоолгон өгч, 4 хүний асаргааг сунгалаа.

5. ЦАГААННУУР ТОСГОН

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Удирдах ажилтны шуурхай хуралдааныг 3 удаа хийж 7 хоногийн болон цаг үеийн тулгамдсан асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэр гаргаж ажиллаа.

Аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн “Шуурхай штаб байгуулах, хорио цээрийн дэглэм тогтоох тухай” А/313 тоот, мөн өдрийн “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/318 тоот захирамжуудын дагуу тосгоны нутаг дэвсгэрт 4 дүгээр сарын 30-ны 23:00 цагаас 5 дугаар сарын 6-ны өдрийн 20:00 цаг хүртэл хорио цээрийн дэглэм тогтоон тосгоны Онцгой комиссын бүрэлдэхүүн, мэргэжлийн ангийг өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэн ажиллав.

2019 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагаар тэнцсэн 8 цэргийг аймагт хүргүүлэн шинжилгээнд хамруулж алба хаах ангиудад нь хүргүүлэн өгөв.

Аймгийн Засаг даргын А/338 тоот захирамжаар дархлаажуулалтын 10 хоногийн аяныг зохион байгуулж тосгоны 5-18 насны 285 хүүхдийг улаан бурхан, улаануудын эсрэг вакцинд хамруулан дархлаажуулав.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн хүрээнд ажлын хэсэг байгуулан, улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөө гарган ажиллаж байна.

“Эрүүл хүнс” сарын аяны хүрээнд тосгоны төсвийн байгууллагуудын хүнсний бүтээгдэхүүний склад, хүнсний бүтээгдэхүүний хадгалалтад, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, гал тогооны ундны усны ариун цэвэр эрүүл ахуйн нөхцөлд хяналт-шалгалт хийж шалган зөвлөсөн.

Мөн хуванцар савны хэрэглээний талаар болон хоолны хордлогын үед авах анхан шатны тусламжийн тухай сурагчдад Эрүүл мэндийн төвийн эмч нар сургалт явуулав.

Монгол улсын Засгийн газрын 384 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын А/188 дугаар захирамж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд тосгоны веб сайтад мэдээ, захирамж, төсөвт байгууллагуудын сарын мэдээ, жилийн төсөв, хөрөнгөтэй холбоотой мэдээллүүдийг тогтмол тавьж байна.

Хоёр. Төсөв, санхүүгийн бодлогын талаар

1. Хилийн 0285-р анги	Үндсэн цалин	-	240,889,864.00 төгрөг
2. Дунд Сургууль	Үндсэн цалин	-	28,125,400.00 төгрөг
3. Хүүхдийн Цэцэрлэг	Үндсэн цалин	-	13,962,800.00 төгрөг
4. Эрүүл мэндийн төв	Үндсэн цалин	-	17,182,300.00 төгрөг
5. Соёлын төв	Үндсэн цалин	-	6,200,500.0 төгрөг
6. Захирагчийн алба	Үндсэн цалин	-	10,076,800.00 төгрөг
Бүгд			306,360,864.00 төгрөг

Төсөвт байгууллагуудын өглөгүүд:

-Дунд сургууль	-	3,964,124.0 төгрөг
-Захирагчийн алба	-	5,953,958.0 төгрөгийн өглөгүүд тус тус гарсан байна.

Гурав. Статистик мэдээний талаар

Том малын зүй бус хорогдлын мэдээ:	- Төллөсөн хээлтэгч	- 9886
Үүнээс	- Гарсан төл	- 9886
	- Хорогдсон төл	- 373
	- Бойжсон төл	- 9513
Том малын зүй бус хорогдлын мэдээ	- Хорогдсон том мал	- 316
	- Өвчнөөр хорогдсон	- 196
	- Хорогдсон хээлтэгч	- 120

Дөрөв. Боловсрол, соёлын талаар**4.1. Боловсролын талаар****4.1.1. Дунд сургуулийн мэдээлэл**

5-р сарын 8-наас 15-ныг хүртэл “Математикийн хичээлийг сурталчлах 7 хоногийн аян”-ыг тусгай төлөвлөгөөний дагуу математикийн багш, бага ангийн багш нар хамтран зохион байгуулав.

Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газраас ирсэн төлөөлөгчид тосгоны багш нар болон 5-р ангийн сурагчдаас түвшин тогтоох шалгалт авав.

Мөн сургуулийн төгсөх ангийн сурагчдаас түвшин тогтоох шалгалт авч өмнөх шалгалтын дүнтэй харьцуулалт хийж өсөх бууралтын график байгуулан анализ хийв.

Сургуулийн 7, 8, 9-р ангийн сурагчдад Нийгмийн ажилтан, Эрүүл мэндийн багштай хамтран архи тамхины хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх, бусад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай сургалт явуулж, зөвлөгөө өгөв.

5-16 насны сурагчдыг вакцинжуулах аяны хүрээнд тосгоны Эрүүл мэндийн төвийн вакцинолог, сувилагч, сургуулийн Нийгмийн ажилтан, сургуулийн эмч нартай хамтран хүүхдүүдийг улаан бурхны вакцинжуулалтад бүрэн хамруулав.

Сургуулийн анги, танхим, гал тогооны өрөөнүүдэд ариутгал хийлгэж халдваргүйжүүлэх арга хэмжээ авч ажиллав.

Улсын болон анги дэвших шалгалтын хуваарь сургуулийн захирлын тушаалаар батлагдан гарч, Улсын шалгалтын булан байгуулагдан 27-ноос шалгалт эхлэхээр хуваарьт тусгагдан ажиллаж байна.

4.1.2. Хүүхдийн цэцэрлэгийн мэдээлэл

Тосгоны хэмжээнд байгаа бэлтгэл бүлгийн хүүхдийн судалгааг гаргаж нийт 20 хүүхдийг бэлтгэл бүлэгт хамруулж стандартын дагуу сургалт хүмүүжлийн ажлыг бага ангийн багш нартай хамтран 2019 оны 5-р сарын 8-ны өдрөөс эхлэн 5-р сарын 15-ны өдөр хүртэл 7 хоног зохион байгуулав.

Бүлгийн хүүхдүүдийн бие бялдрын сорил, мөн хөгжлийн ахицын түүвэр үнэлгээг гаргаж улсын дундажтай харьцуулсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн 9,5 сая төгрөгийн төслөөр цэцэрлэгийн хашааг шинэчилж байгаа ба хүлээлгэж өгөх шатандаа байна.

4.2. Соёлын талаар

“Шавь сургалт” ажлын хүрээнд Соёлын төвийн хөгжмийн багш сургуулийн нийт 15 сурагчдад домбрын аялгууг зааж сургасан ба бүжгийн багш мөн сургуулийн сурагчдад “сургалт зохион байгуулсан.

Номын санч сургуулийн сурагчдын дунд “Уран зохиолын амтыг мэдэрье” 3 сарын аяныг амжилттай зохион байгуулав.

“Эх үрсийн баяр”-ыг тохиолдуулан сургуулийн сурагчдын дунд “Анши балапан-2019” дуу, бүжгийн уралдааныг зохион байгуулах удирдамж гарган ажиллаж байна.

Тав. Эрүүл мэндийн талаар

Бүх үзлэг	-	529
-Урьдчилан сэргийлэх үзлэг	-	285
-Амбулаторийн үзлэг	-	95
-Гэрийн дуудлагын тоо	-	43
-Алсын дуудлага	-	18
-Нас баралт	-	3
-Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн	-	38
-Эмнэлгээс эмчлүүлж гарсан	-	35
-Аймагт төрсөн эх	-	2
-Өөрийн эмнэлэгт төрсөн	-	0
-Аймагт шилжүүлсэн жирэмсэн эх	-	3
-Хяналтад байгаа жирэмсэн эх	-	20
-Шинээр хяналтад авсан жирэмсэн эх	-	4
- Дархлаажуулалтад	-	20 иргэн тус тус хамрагдсан байна.

Зургаа. Улсын бүртгэлийн талаар

Улсын бүртгэлийн 8 төрлийн бүртгэлд:

-Төрөлт	-	1
-Нас баралт	-	2
-Шилжин ирсэн	-	2
-Тараасан цахим үнэмлэх	-	5
-Цахим үнэмлэх шинээр	-	1
-Цахим үнэмлэх сунгалт	-	2 тус тус бүртгэгдсэн болно.

Долоо. Нийгмийн халамж, хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн талаар

Нийгмийн халамж, үйлчилгээнээс авах хүмүүсийн тэтгэвэр тэтгэмжүүдийг олгох ажлыг зохион байгуулж, Улаанбаатар хотод явж эмчилгээ хийлгэж ирсэн 2 ахмад настанд замын зардал болон сонсголын аппаратын хөнгөлөлтийн мөнгийг нь буцаан олгов. Мөн цалинтай ээж хөтөлбөрт 2 эхийг хамруулж, 3 жирэмсэн хөхүүл хүүхэдтэй эхэд нөхцөлт мөнгөн тэтгэмж тогтоолгов.

Найм. Нийгмийн даатгалын талаар.

3 иргэнд жирэмсний амаржсаны тэтгэмж, 1 иргэнд Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгов.

Шинээр 1 хүн өндөр насны тэтгэвэр, 1 хүн цэргийн тэтгэвэр тогтоолгов.